

УЛААНБААТАР ХОТЫН 2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН АГААРЫН ЧАНАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ


Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн бүс орчмын 19 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), $\text{PM}_{2.5}$, PM_{10} тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3) болон цаг уурын үзүүлэлтүүдийг тасралтгүй хэмжилтийн автомат анализатороор тодорхойлж байна.

Улаанбаатар хотын агаар бохирдуулах бодисын 2026 оны 05 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2025 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад $\text{PM}_{2.5}$ тоосонцор 1 мкг/м^3 -ээр буюу 7 %-иар, PM_{10} тоосонцор 11 мкг/м^3 -ээр буюу 15 %-иар, хүхэрлэг хий (SO_2) нь 4 мкг/м^3 -ээр буюу 31 %-иар, азотын давхар исэл (NO_2) нь 3 мкг/м^3 -ээр буюу 12 %-иар тус тус бага байна.

Хүснэгт 1. Агаар дахь бохирдуулах бодисын 2025, 2026 оны 05 дугаар сарын дундаж агууламж


Бохирдуулах бодисын нэр	Сарын дундаж агууламж, мкг/м^3	
	2025 оны 05 дугаар сар	2026 оны 05 дугаар сар
$\text{PM}_{2.5}$ тоосонцор	14	13
PM_{10} тоосонцор	73	62
Хүхэрлэг хий, SO_2	13	9
Азотын давхар исэл, NO_2	25	22

Улаанбаатар хотын 2026 оны 05 дугаар сарын агаар бохирдуулах бодис тус бүрийн сар, хоногийн дундаж агууламжийг дараах зурагт харууллаа. (Зураг 1-13)




Зураг 1. 2025, 2026 оны 05 дугаар сарын агаар бохирдуулах бодисын дундаж агууламж

PM2.5 тоосонцор



Зураг 2. PM2.5 тоосонцрын 05 дугаар сарын агууламж, 2021-2026 он


Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын 2026 оны 05 дугаар сарын дундаж агууламжийг 2021 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 2 мкг/м³-ээр буюу 14 %-иар бага, 2022, 2023, 2024 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад ижил түвшинд, 2025 оны 05 дугаар сарын дундаж агууламжаас 2 мкг/м³-ээр буюу 14 %-иар бага байна. (Зураг 2).



Зураг 3. PM2.5 тоосонцрын 05 дугаар сарын дундаж агууламж агаарын чанарын станц тус бүрээр

2026 оны 05 дугаар сарын PM2.5 тоосонцрын дундаж агууламжийг 2025 оны 05 дугаар сартай харьцуулахад Мишээл экспо 2 мкг/м³-ээр, Баруун 4 зам 3 мкг/м³-ээр, Ургах наран хороолол 3 мкг/м³, Хайлааст 6 мкг/м³-ээр, Шархад 1 мкг/м³-ээр, Налайх 7 мкг/м³-ээр, Яармаг 2 мкг/м³-ээр, Нисэх 1 мкг/м³-ээр, Толгойт 6 мкг/м³-ээр, Зурагт 4 мкг/м³-ээр, Баянхошуу 1 мкг/м³-ээр бага байна. Харин 100 айл ижил түвшинд байсан байна.


1-р хороолол 1 мкг/м³-ээр, Бөхийн өргөө 5 мкг/м³-ээр, Цахилгаан станц 8 мкг/м³-ээр, Зайсан 10 мкг/м³-ээр, Дамбадаржаа 1 мкг/м³-ээр их байна (Зураг 3).



Зураг 4. PM2.5 тоосонцрын 05 дугаар сарын хоногийн дундаж агууламж


2026 оны 05 дугаар сарын PM2.5 тоосонцрын хоногийн дундаж агууламж 1-63 мкг/м³ байсан байна. PM2.5 тоосонцрын хамгийн бага агууламж нь 05 дугаар сарын 01-нд Хайлааст орчим 1 мкг/м³, харин хамгийн өндөр агууламж илэрсэн цэг 05 дугаар сарын 12-нд Цахилгаан станц орчим 63 мкг/м³ буюу MNS 4585:2025 АЧС-аас 1.6 дахин их байсан байна (Зураг 4).

PM10 тоосонцор




Зураг 5. PM10 тоосонцрын 05 дугаар сарын дундаж агууламж, 2021-2026 он

Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын 2026 оны 05 дугаар сарын дундаж агууламжийг 2021 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 6 мкг/м³-ээр буюу 11 %-иар их, 2022 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 15 мкг/м³-ээр буюу 19 %-иар бага, 2023 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 7 мкг/м³-ээр буюу 13 %-иар их, 2024 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад ижил түвшинд, 2025 оны 05 дугаар сарын дундаж агууламжаас 11 мкг/м³-ээр буюу 15 %-иар бага байна. (Зураг 5).




Зураг 6. PM10 тоосонцрын 05 дугаар сарын дундаж агууламж агаарын чанарын станц тус бүрээр

2026 оны 05 дугаар сарын PM10 тоосонцрын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2025 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад Баруун 4 зам 9 мкг/м³-ээр, Бөхийн өргөө 1 мкг/м³-ээр, 100 айл 2 мкг/м³-ээр, Ургах наран хороолол 6 мкг/м³-ээр, Нисэх 2 мкг/м³-ээр, Толгойт 31 мкг/м³-ээр, Зурагт 20 мкг/м³-ээр, Дамбадаржаа 6 мкг/м³-ээр тус тус бага, харин Мишээл экспо 12 мкг/м³-ээр, Хайлааст 15 мкг/м³-ээр их, 5 буудал 13 мкг/м³-ээр, Зайсан 31 мкг/м³-ээр, Шархад 1 мкг/м³-ээр, Налайх 11 мкг/м³-ээр, Яармаг 15 мкг/м³-ээр их байна. (Зураг 6).




Зураг 7. PM10 тоосонцрын 05 дугаар сарын хоногийн дундаж агууламж

2026 оны 05 дугаар сарын PM10 тоосонцрын хоногийн дундаж агууламж 5-249 мкг/м³ байсан байна. PM10 тоосонцрын хамгийн бага агууламж нь 05 дугаар сарын 31-нд Нисэх орчим 5 мкг/м³, харин хамгийн өндөр агууламж илэрсэн цэг 05 дугаар сарын 30-нд Яармаг орчим 249 мкг/м³ буюу MNS 4585:2025 АЧС-аас 2.4 дахин их байсан байна (Зураг 7).

Азотын давхар исэл (NO₂)


Зураг 8. Азотын давхар ислийн 05 дугаар сарын дундаж агууламж, 2021-2026 он

Азотын давхар ислийн (NO₂) 2026 оны 05 дугаар сарын дундаж агууламжийг 2021-2024 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 2-14 мкг/м³-ээр буюу 8-39 %-иар бага, 2025 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 3 мкг/м³-ээр буюу 12 %-иар бага байна (Зураг 8).



Зураг 9. Азотын давхар ислийн 05 дугаар сарын дундаж агууламж агаарын чанарын станц тус бүрээр


2026 оны 05 дугаар сарын азотын давхар исэл (NO₂)-ийн дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2025 оны 05 дугаар сартай харьцуулахад Мишээл экспо 2 мкг/м³, Баруун 4 зам 7 мкг/м³-ээр, 100 айл 3 мкг/м³-ээр, Цахилгаан станц 5 мкг/м³-ээр, Ургах наран хороолол 14 мкг/м³-ээр, Зайсан 9 мкг/м³-ээр, Шархад 9 мкг/м³-ээр, Яармаг 6 мкг/м³-ээр, Толгойт 2 мкг/м³-ээр, Зурагт 1 мкг/м³-ээр тус тус бага, Бөхийн өргөө 2 мкг/м³-ээр их, харин Хайлааст, Налайх жил түвшинд байна (Зураг 9).



Зураг 10. Азотын давхар ислийн 05 дугаар сарын хоногийн дундаж агууламж


2026 оны 05 дугаар сарын азотын давхар исэл (NO₂)-ийн хоногийн дундаж агууламж 1-67 мкг/м³ байсан байна. Азотын давхар исэл (NO₂)-ийн хамгийн бага агууламж нь 05 дугаар сарын 14, 18, 20, 21, 26-нд Мишээл экспо орчим 1 мкг/м³, харин хамгийн өндөр агууламж илэрсэн цэг 05 дугаар сарын 29-нд Бөхийн өргөө орчим 67 мкг/м³ буюу MNS 4585:2025 АЧС-аас 1.3 дахин их байсан байна (Зураг 10).

Хүхэрлэг хий (SO₂)




Зураг 11. Хүхэрлэг хийн 05 дугаар сарын дундаж агууламж, 2021-2026 он

Агаар дахь хүхэрлэг хийн (SO₂) 2026 оны 05 дугаар сарын дундаж агууламжийг 2021-2024 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 6-10 мкг/м³-ээр буюу 40-53 %-иар бага, өмнөх оны мөн үе буюу 2025 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 4 мкг/м³-ээр буюу 31 %-иар бага байна (Зураг 11).





Зураг 12. Хүхэрлэг хийн 05 дугаар сарын дундаж агууламж агаарын чанарын станц тус бүрээр



2026 оны 05 дугаар сарын хүхэрлэг хий (SO₂)-н дундаж агууламжийг 2025 оны 05 дугаар сартай харьцуулахад Мишээл экспо 3 мкг/м³-ээр, Баруун 4 зам 5 мкг/м³-ээр, 1-р хороолол 12 мкг/м³-ээр, Бөхийн өргөө 5 мкг/м³-ээр, 100 айл 3 мкг/м³-ээр, Цахилгаан станц 4 мкг/м³-ээр, Зайсан 2 мкг/м³-ээр, Шархад 2 мкг/м³-ээр, Налайх 3 мкг/м³-ээр, Яармаг 4 мкг/м³-ээр, Толгойт 10 мкг/м³-ээр тус тус бага, Хайлааст, Баянхошуу ижил түвшинд, харин Ургах наран хороолол 1 мкг/м³-ээр их байна (Зураг 12).




Зураг 13. Хүхэрлэг хийн 05 дугаар сарын хоногийн дундаж агууламж

2026 оны 05 дугаар сарын хүхэрлэг хийн (SO₂) хоногийн дундаж агууламж 1-41 мкг/м³ байсан байна. Хүхэрлэг хийн (SO₂) хамгийн бага агууламж нь Мишээл экспо, 1-р хороолол, Цахилгаан станц, Зайсан орчим 1 мкг/м³, харин хамгийн их агууламж илэрсэн цэг 05 дугаар сарын 07-нд Мишээл экспо орчим 41 мкг/м³ хүрсэн боловч MNS 4585:2025 АЧС-аас даваагүй байна (Зураг 13).





2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН АГААРЫН ЧАНАРЫН ИНДЕКС,
/АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ СТАНЦ ТУС БҮРЭЭР ҮЗҮҮЛЭВ/



УЛААНБААТАР ХОТЫН 2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН
ЦАГ АГААРЫН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ /2025 ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАВ/

№	Цаг уурын үзүүлэлт	2025 оны 05 дугаар сарын дундаж	2026 оны 05 дугаар сарын дундаж	Тайлбар
1	Агаарын дундаж температур °C	10.9 °C	11.6 °C	0.7 °C-аар их
2	Салхины дундаж хурд, м/с	2.8 м/с	3.0 м/с	0.2 м/с-ээр их салхитай
3	Сарын нийлбэр хур тунадас, мм	10.3 мм	17.8 мм	17.8 мм хур тунадастай